



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/659

Ховд

Нүүдлийн авто замын засвар арчлалт /Ховд/-н 5 дугаар багц ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Силкрөүд номадс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Нүүдлийн авто замын засвар арчлалт /Ховд/-н 5 дугаар багц ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ганзориг

- Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын Улсын байцаагч

И.Гантогтох

- Ховд аймаг дахь цагдаагийн газрын ахлах зохицуулагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар

- Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Д.Сонгууль

- Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Ш.Гансүх

- Булган сумын байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
Т.Ганбаатар - “Силкрөүд номадс” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын мэргэжилтэн

2. “Силкрөүд номадс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН